



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/172/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг:
erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodoli@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг
Утас: 99377360 Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	1-2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9-11
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт	13-14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	15-16
7. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	17
8. Төлбөрийн акт, 01/153, 02/154, 03/155.....	21-25
9. Албан шаардлага, 01/117, 02/118.....	26-27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 269

танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бүрэгхангай сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын ойн арга хэмжээтэй уялдуулан багш ажилтнуудад 4,896.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон.

Цагийн тооцоонд тусгагдаагүй өдөрт цалин тооцсон, сурагчид амарсан, дотуур байр ажиллаагүй, тогооч нарт амралттай байх хугацаанд 5,245.0 мянган төгрөгийн цалин, илүү цагийн хөлс тооцож олгосон.

Сургуулийн сантехникчтэй ажлын чиг үүрэг давхардсан сантехникийн засвар хийх тухай 1,480.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ч ажлын гүйцэтгэл байхгүй, гэрээг дүгнээгүй байна.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа, зөрчлийн нийт дүн 11,621.7 мянган төгрөг байгаа нь төлөвлөсөн материаллаг байдлын түвшнөөс давсан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

006020712

Ур чадварын нэмэгдэлд тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэлгүйгээр 28,321.9 мянган төгрөг олгосон нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөдмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын хавсралт дахь 2, 3, 4-т заасныг зөрчсөн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдлийг хангаагүй санхүүгийн тайлан, төвийн гүйцэтгэлийн тайлан ирүүлсэн нь УСНББОУС 1, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэгдээгүй, төсвийн шууд захирагчид үр дүнгийн урамшуулал олгогдоогүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,426,173.69	101,481,300.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	42,923,239.45	32,206,753.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	42,923,239.45	32,206,753.40
3121	Төгрөг	42,923,239.45	32,206,753.40
31211	Төрийн сангийн харилцах	42,923,239.45	32,206,753.40
33	АВЛАГА	-	1,800,000.00
335	Бусад авлага	-	1,800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,502,934.24	67,474,546.84
351	Түүхий эд материал	-	716,000.00
35130	Эм боох материал	-	716,000.00
354	Хангамжийн материал	79,502,934.24	66,758,546.84
35410	Бичиг хэргийн материал	2,736,440.00	2,451,300.00
35420	Аж ахуйн материал	62,770,939.24	43,893,958.34
35460	Хүнсний материал	11,070,705.00	16,357,188.50
35470	Бусад хангамжийн материал	2,924,850.00	4,056,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,235,262,557.40	2,181,340,959.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,235,262,557.40	2,181,340,959.94
392	Биет хөрөнгө	2,189,896,828.93	2,136,917,051.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,151,278,942.60	2,151,278,942.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(207,558,500.01)	(285,156,805.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,000,000.00	11,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,872,222.17)	(3,605,555.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,961,856.45	267,554,706.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,273,020.34)	(86,770,286.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,215,824.46	135,515,824.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,577,417.58)	(66,621,139.26)
39217	Ном	13,721,365.52	13,721,365.52
393	Биет бус хөрөнгө	45,365,728.47	44,423,907.99
39303	Бусад биет бус хөрөнгө	48,458,010.39	48,458,010.39
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,092,281.92)	(4,034,102.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,357,688,731.09	2,282,822,260.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,789,613.78	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,789,613.78	
41361	Байгууллагад төлөх өглөг	11,789,613.78	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,345,899,117.31	2,282,822,260.18

51	Засгийн газрын хувь оролцоо	2,345,899,117.31	2,282,822,260.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,517,804.44	269,517,804.44
512	Хуримтлагдсан үр дүн	1,063,334,995.97	1,000,258,138.84
51210	Өмнөх үеийн үр дүн	1,063,334,995.97	1,075,124,609.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(74,866,470.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,013,046,316.90	1,013,046,316.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,357,688,731.09	2,282,822,260.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,510,508,788.90	1,321,381,050.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	411,025,288.90	46,760,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	378,930,488.90	46,760,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	375,681,258.90	1,818,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөр	1,669,030.00	44,551,950.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого –Бараа мат	1,580,200.00	
120009	Бусад орлого	-	390,000.00
122	Тусламжийн орлого	32,094,800.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	32,094,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,099,483,500.00	1,274,620,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	885,975,500.00	1,050,423,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,975,500.00	1,050,423,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	213,508,000.00	224,197,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	213,508,000.00	224,197,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,106,817,466.13	1,396,247,520.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,106,817,466.13	1,396,247,520.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,060,818,517.49	1,352,472,446.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,416,455.29	782,245,993.54
210101	Үндсэн цалин	478,994,575.29	549,698,591.46
210102	Нэмэгдэл	118,987,052.00	208,108,952.08
210104	Урамшуулал	24,434,828.00	24,438,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,002,836.62	96,821,042.95
210201	Тэтгэврийн даатгал	52,843,379.43	65,659,003.72
210202	Тэтгэмжийн даатгал	6,439,293.42	7,790,334.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,955,910.99	6,232,387.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,251,504.68	1,558,046.09
210205	Эрүүл мэндийн даатгал	12,512,748.10	15,581,271.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,783,349.00	220,177,586.17
210301	Гэрэл, цахилгаан	8,018,048.00	14,890,385.93

210302	Түлш, халаалт	172,639,328.00	204,294,078.00
210303	Цэвэр, бохир ус	1,125,973.00	993,122.24
2104	Хангамж, бараа материалын зардал	1,388,400.00	20,502,480.90
210401	Бичиг хэрэг	130,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	77,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,180,800.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	20,502,480.90
2105	Нормативт зардал	60,321,894.60	72,533,156.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	-
210502	Хоол, хүнс	60,261,894.60	72,533,156.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,350,300.00	3,675,150.00
210604	Урсгал засвар	4,350,300.00	3,675,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,091,800.00	4,385,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,580,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,511,600.00	4,385,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,463,481.98	152,132,037.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,859,651.00	27,356,595.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,618,249.00	5,960,994.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,985,581.98	118,814,447.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,998,948.64	43,775,074.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,721,990.00	43,470,210.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,721,990.00	43,470,210.40
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	276,958.64	304,863.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	276,958.64	304,863.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	403,691,322.77	(74,866,470.91)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	403,691,322.77	(74,866,470.91)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1,099,483,500.00	1,276,829,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,208,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,208,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,818,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,818,500.00
120009	Бусад орлого	-	390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,099,483,500.00	1,274,620,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	885,975,500.00	1,050,423,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,975,500.00	1,050,423,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	213,508,000.00	224,197,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	213,508,000.00	224,197,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,027,525,260.55	1,267,204,686.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,027,525,260.55	1,267,204,686.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	976,220,636.91	1,217,642,622.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,001,115.51	782,245,993.54
210101	Үндсэн цалин	472,225,232.58	549,698,591.46
210102	Нэмэгдэл	124,341,055.21	208,108,952.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	24,434,827.72	24,438,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,441,997.40	96,821,042.95
210201	Тэтгэврийн даатгал	53,131,735.42	65,659,003.72
210202	Тэтгэмжийн даатгал	6,426,077.80	7,790,334.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,149,006.62	6,232,387.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248,861.48	1,558,046.09
210205	Эрүүл мэндийн даатгал	12,486,316.08	15,581,271.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,759,528.00	220,177,586.17
210301	Гэрэл, цахилгаан	8,994,227.00	14,890,385.93
210302	Түлш, халаалт	172,639,328.00	204,294,078.00
210303	Цэвэр, бохир ус	1,125,973.00	993,122.24
2105	Нормативт зардал	59,059,956.00	72,032,650.00
210502	Хоол, хүнс	59,059,956.00	72,032,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	3,715,150.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,715,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,196,800.00	6,282,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,580,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,616,600.00	6,282,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,261,240.00	36,367,779.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,398,490.00	28,472,379.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,862,750.00	7,895,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,304,623.64	49,562,063.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,027,665.00	49,257,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,027,665.00	49,257,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	276,958.64	304,863.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	276,958.64	304,863.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	71,958,239.45	9,624,413.95
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,035,000.00	20,340,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,035,000.00	20,340,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,035,000.00	20,340,900.00
222001	Тоног төхөөрөмж	26,599,000.00	20,040,900.00

223001	Бусад хөрөнгө	2,436,000.00	300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(29,035,000.00)	(20,340,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	42,923,239.45	(10,716,486.05)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		42,923,239.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,923,239.45	32,206,753.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	1,063,334,995.97	2,345,899,117.31
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	1,063,334,995.97	2,345,899,117.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			11,789,613.78	11,789,613.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			(74,866,470.91)	(74,866,470.91)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	1,000,258,138.84	2,282,822,260.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,317,543,700.00	1,287,240,722.22	30,302,977.78	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,317,543,700.00	1,266,899,822.22	50,643,877.78	96.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,262,673,700.00	1,217,642,622.22	45,031,077.78	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,942,600.00	782,245,993.54	20,696,606.46	97.4
210101	Үндсэн цалин	570,813,300.00	549,698,591.46	21,114,708.54	96.3
210102	Нэмэгдэл	208,793,900.00	208,108,952.08	684,947.92	99.7
210104	Урамшуулал	23,335,400.00	24,438,450.00	(1,103,050.00)	104.7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,367,800.00	96,821,042.95	3,546,757.05	96.5
210201	Тэтгэврийн даатгал	68,250,100.00	65,659,003.72	2,591,096.28	96.2
210202	Тэтгэмжийн даатгал	8,029,300.00	7,790,334.50	238,965.50	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,423,600.00	6,232,387.41	191,212.59	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,605,900.00	1,558,046.09	47,853.91	97.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,058,900.00	15,581,271.23	477,628.77	97.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,397,600.00	220,177,586.17	220,013.83	99.9
210301	Гэрэл, цахилгаан	15,100,000.00	14,890,385.93	209,614.07	98.6
210302	Түлш, халаалт	204,297,600.00	204,294,078.00	3,522.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	993,122.24	6,877.76	99.3
2105	Нормативт зардал	72,036,000.00	72,032,650.00	3,350.00	100.0
210502	Хоол, хүнс	72,036,000.00	72,032,650.00	3,350.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,800,000.00	3,715,150.00	84,850.00	97.8
210604	Урсгал засвар	3,800,000.00	3,715,150.00	84,850.00	97.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,290,400.00	6,282,420.00	7,980.00	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,290,400.00	6,282,420.00	7,980.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,839,300.00	36,367,779.56	20,471,520.44	64.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,403,700.00	28,472,379.56	18,931,320.44	60.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,435,600.00	7,895,400.00	1,540,200.00	83.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,870,000.00	49,257,200.00	5,612,800.00	89.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,870,000.00	49,257,200.00	5,612,800.00	89.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,870,000.00	49,257,200.00	5,612,800.00	89.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	20,340,900.00	(20,340,900.00)	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	20,340,900.00	(20,340,900.00)	
222001	Тоног төхөөрөмж	-	20,040,900.00	(20,040,900.00)	
223001	Бусад хөрөнгө	-	300,000.00	(300,000.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,274,620,600.00	1,276,829,100.00	(2,208,500.00)	100.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,050,423,000.00	1,050,423,000.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,050,423,000.00	1,050,423,000.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	224,197,600.00	224,197,600.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	224,197,600.00	224,197,600.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,208,500.00	(2,208,500.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,818,500.00	(1,818,500.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		390,000.00	(390,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		42,923,239.45	(42,923,239.45)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		32,206,753.40	(32,206,753.40)	

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Бүрэгхэнгай сумын ЕБС нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант оны хичээлийн жилд 18 бүлэгт 376 сурагчид , 29 багш 16 ажилтны орон тоогоор удирдлагын баг, заах аргын 4 нэгдэл, захиргаа аж ахуй гэсэн бүтэцтэйгээр "Эрдэм боловсролтой , эх оронч сэтгэлтэй ,эрүүл биетэй ирээдүйн иргэнийг бэлгэх, сурагчдад бага дунд, бүрэн дунд боловсрол олгох ,чанарыг дээшлүүлнэ." гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ.

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол,"Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан

бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,866.6 мянган төгрөгөөр буюу 3.17 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	42,923.2	32,206.7	(10,716.5)
Авлага		1,800.0	1,800.0
Байгууллагаас авах авлага			
Бараа материал	79,502.9	67,474.5	(12,028.4)
Үндсэн хөрөнгө	2,562,636.0	2,627,528.8	64,892.8
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(327,373.4)	(446,187.9)	(118,814.5)
Нийт хөрөнгө	<u>2,357,688.7</u>	<u>2,282,822.1</u>	<u>(74,866.6)</u>
Өр төлбөр	11,789.6	0.0	(11,789.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,345,899.1	2,282,822.3	(63,076.8)
Өр төлбөр /богино хугацаат/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,357,688.7</u>	<u>2,282,822.1</u>	<u>(74,866.6)</u>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оныхоос 10,716.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 1,800.0 мянган төгрөгийн авлага шинээр үүсгэжээ.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 12,028.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,627,528.8 мянган төгрөг болж өмнөх оны оноос 64,892.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 225,604.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 26,036.8 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 20,340.9 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн тайланд тусгасан байна. БШУЯ-аас шилжүүлсэн 44,551.9 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд 118,814.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,282,822.3 мянган төгрөг болж 63,076.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийг 866,414.2 мянган төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 1,050,423.0 мянган төгрөгөөр буюу 184,008.8 мянган төгрөгөөр нэмж баталсан нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,050,423.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 224,197.6 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,050,423.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 32,206.7 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаж, тайлагнаагүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,106,817.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,068.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар тооцон 7,747.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон асуудлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 5 акт, 3 албан шаардлага, 6 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	5	4,383.8	5	4,383.8	100
Албан шаардлага	3	121,149.6	1	121,149.6	100
Зөвлөмж	6	1,388.0	3	1,388.0	100
Нийт дүн	14	126,921.4	14	126,921,42	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 2,698.5 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 40,973.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 11,621.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 16,759.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 12,592.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тус сумын 100 жилийн ойн баярын үйл ажиллагаатай холбогдуулан сургуулийн багш, ажилтнуудад 4,896.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын 12-т “Ур чадварын нэмэгдлийг тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалзан олгохыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Багш, ажилтнуудад ажиллаагүй, амралттай байх хугацаанд 5,245.1 мянган төгрөгийн цалин, илүү цагийн хөлс тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3. Сургуулийн слесарь, сантеникч ажилтай Ч.Билэгдэмбэрэлтэй ажлын чиг үүрэгтэй нь давхардсан 1,480.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ч уг гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын гүйцэтгэл байхгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,030.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

2. Ур чадварын нэмэгдлийг багш, ажилтнуудад олгохдоо тухайн ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй, захирлын тушаалд харгалзах үндэслэл заагаагүй, 15,729.1 мянган төгрөг хавтгайруулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын 4-т “Шалгуур үзүүлэлтийн 3-т заасан нийтлэг шалгуурыг хангасан ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ”, 12-т “Ур чадварын нэмэгдлийг тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалзан олгохыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдлийг сургуулийн багш ажилчдад олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр 12,592.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9-р тушаалын 4.4, 10 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтны ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр дүгнэж, шаардлага хангасан багш, ажилтанд ур чадварын нэмэгдлийг тушаал, шийдвэрийг үндэслэн батлагдсан төсөвтөө багтааж олгох.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
					Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Сургалтын зардлыг авлагад тусгуулсан.	1	1,800.0	1	1,800.0		1	1,800.0					
Хүнсний материалын зардал өссөн	1	898.5			1	898.5						
Дүн	2	2,698.5	1	1,800.0	1	898.5	1	1,800.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын 100 жилийн ойн баярын үйл ажиллагаатай холбогдуулан ур чадварын нэмэгдэл олгосон.	1	4,896.7	1	4,896.7								
Багш, ажилтнуудад ажиллаагүй, амралттай байх хугацаанд цалин, илүү цагийн хөлс олгосон	1	5,245.1	1	5,245.1								
Ч.Билэгдэмбэрэлтэй ажлын чиг үүрэгтэй нь давхардсан 1,480.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ч уг гэрээг дүгнээгүй	1	1,480.0	1	1,480.0								
Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж төлбөр төлсөн.	1	1,030.0			1	1,030.0						
Ур чадварын нэмэгдлийг багш, ажилтнуудад олгохдоо тухайн ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй, захирлын тушаалд харгалзах үндэслэл заагаагүй	1	15,729.1			1	15,729.1						
Ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур	1	12,592.8					1	12,592.8				

